

## **МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БОДЛОГО**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

“МАНДАЛ ДИЖИТАЛ КРЕДИТ” ББСБ (цаашид “Байгууллага” гэх) –ын үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээлэл, мэдээллийн систем, дэд бүтэц, тэдгээрийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдал, тасралтгүй ажиллагаа, хяналтыг хэрэгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг олон улсын стандартын дагуу тасралтгүйгээр өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдөхөд энэ бодлогын зорилго оршино.

### **ХОЁР. ДЭЭД УДИРДЛАГЫН МАНЛАЙЛАЛ**

Байгууллагын Гүйцэтгэх захирал нь мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэхэд бүхий л талаар дэмжиж, үр дүнтэй байдлыг хангахад дараах үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, зорилтуудыг байгууллагын стратегийн чиглэл, бизнес төлөвлөгөө, нөхцөл байдалтай уялдаатай боловсруулж, батална.
2. Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны (цаашид “МАБМТ- гэх)-г шаардлагыг байгууллагын үндсэн болон бусад үйл явцтай уялдуулж нэгтгэх нөхцөлөөр хангана.
3. МАБМТ-ыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийн бэлэн байдлыг хангана.
4. МАБМТ-ын шаардлагыг дагаж мөрдөх, мэдээллийн аюулгүй байдлын үр дүнтэй менежментийн ач холбогдлын талаар тодорхой ойлголтыг нийт ажилтнуудад өгөх үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, тасралтгүй хэрэгжүүлнэ.
5. МАБМТ нь төлөвлөсөн үр дүндээ хүрч байгаа эсэхийг тогтмол давтамжтай хяналт тавьж баталгаажуулна.
6. МАБМТ-ыг үр дүнтэй болгоход хувь нэмрээ оруулах хүмүүсийг удирдан чиглүүлж, урамшуулж, дэмжлэг үзүүлэхээс гадна бусад чиг үүргээр манлайлан ажиллана.
7. МАБМТ-ын үр дүнтэй болгох тасралтгүй сайжруулалтыг дэмжинэ.
8. Монгол улсын хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагыг чандлан мөрдөж ажиллахад анхаарч манлайлах үүргээ биелүүлнэ.

## ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО

1. Харилцагч болон хамтран ажиллагч байгууллагуудынхаа мэдээллийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах ба бүх төрлийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
2. Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон бусад Монгол улсын хууль, Зохицуулагч байгууллагуудаас гаргасан дүрэм, журам, стандартыг чандлан мөрдөнө.
3. Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангахын тулд мэдээлэл алдаж болох сувгуудыг тодорхойлж, мэдээллийг ашиглах, дамжуулах, устгах үйл явцуудыг журамлан MNS ISO/IEC 27001:2023 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог бий болгож, хяналтыг хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулна.
4. Тэргүүлэгч байгууллагуудын нэг болохын төлөө олон улсын стандартуудад тасралтгүй суралцах ба ажилтнуудынхаа мэдлэг чадварыг хөгжүүлж, сайжруулна.